



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/392

Улаанбаатар хот

Аминдэм, эрдсийн бэлдмэл түгээх
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 4.2.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаа дэмжих, өвчлөл, бичил тэжээлийн дутлаас сэргийлэх зорилгоор 2017 оны улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан “Дз аминдэм-3200 ОУН” бэлдмэлийг эмзэг бүлгийн жирэмсэн эмэгтэйчүүдэд түгээх хуваарийг зааврын хамт нэгдүгээр, бага насны хүүхдэд А аминдэм түгээх хуваарийг хоёрдугаар, 5 хүртэлх насны хүүхдэд шингэн сэлбэх уусмал болон цайрын бэлдмэл түгээх хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хуваарийн дагуу түгээлт хийж, тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар/Т.Энхзаяа/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081576

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 24 өдрийн
А/39х дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**“Дз аминдэм–3200 оун” бэлдмэлийг
эмзэг бүлгийн жирэмсэн эмэгтэйчүүдэд
түгээх хуваарь**

Д/д	Аймаг/Дүүрэг	Эмзэг бүлгийн жирэмсэн эмэгтэй (2017 оны төрөлтийн тоонд үндэслэн тооцов. 30%-иар)	Дз аминдэмийн тоо (хайрцаг)
1	Баян-Өлгий	872	180
2	Говь-Алтай	373	78
3	Завхан	454	95
4	Увс	642	135
5	Ховд	647	136
6	Архангай	687	144
7	Баянхонгор	631	132
8	Булган	404	85
9	Орхон	683	144
10	Өвөрхангай	795	160
11	Хөвсгөл	883	180
12	Говьсүмбэр	123	26
13	Дархан-Уул	678	142
14	Дорноговь	438	92
15	Дундговь	323	68
16	Өмнөговь	455	95
17	Сэлэнгэ	709	149
18	Төв	658	138
19	Дорнод	600	126
20	Сүхбаатар	451	95
21	Хэнтий	521	109
Нийслэлийн эрүүл мэндийн газарт			
1	Багануур	175	37
2	Багахангай	34	7
3	Баянгол	1,644	330
4	Баянзүрх	2,505	510
5	Налайх	240	50
6	Сонгинохайрхан	2,255	450
7	Сүхбаатар	930	195
8	Хан-Уул	1,394	280
9	Чингэлтэй	1,139	230
10	Сургалт, нөөц: ЭМЯ-НЭМҮТ	-	94
	Нийт	22,343	4,692

“Дз АМИНДЭМ–3200” БЭЛДМЭЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хүний бие дэх Д аминдэмийн түвшин хангалтгүй байх нь ясны эрдэсжилтэд сөргөөр нөлөөлж, хүүхдийн өсөлт хоцрох, насанд хүрэгчдийн яс зөөлөрч сийрэгжин хугарах эрсдлийг нэмэгдүүлдэг. Д аминдэм дутлын улмаас хүүхдэд рахит өвчин үүсдэг бөгөөд хүүхдийн яс зөөлрөх, ясны хэлбэр өөрчлөгдөх шинж (майга эсвэл саруй хөл гэх мэт)-ээр илэрдэг. Д аминдэм дуталтай холбоотойгоор дархлаа сулрах, цусны даралт ихсэлт, чихрийн шижин, зарим эрхтэний хавдраар өвчлөх эрсдэл нэмэгддэг.

Монгол Улс дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст байрладаг тул суурин оршин суугчид жилийн ихэнх хугацаанд наранд биеэ ил гаргах боломжгүйн зэрэгцээ нарны ташуу тусгалын улмаас биед шингэх хэт ягаан туяаны эрчим нь арьсан дор байгаа Д аминдэмийн урьдал бодисыг идэвхтэй хэлбэрт шилжүүлж, Д аминдэм нийлэгжих хангалттай түвшинд хүрч чаддаггүй юм. Монгол хүн Д аминдэмээр баялаг хүнсийг тогтмол хэрэглэдэггүй, зах зээлд Д аминдэмээр баяжуулсан хүнсний хангамж хангалтгүй байна. Иймээс Монгол хүн Д аминдэмийн дуталд өртөх өндөр эрсдэлтэй.

“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгаагаар 6-59 сартай хүүхдийн 61% Д аминдэм дуталтай, 28.9% нөөц багатай, жирэмсэн эмэгтэйчүүдийн 75 хувь Д аминдэм дуталтай, 20 хувь нөөц багатай байна. (ЭМЯ, НЭМҮТ, НҮБХС, 2017).

Хоёр. Бэлдмэлийн танилцуулга

Их Британы Нэгдсэн Вант Улсын “Internis Pharmaceuticals” компанид үйлдвэрлэсэн энэхүү бэлдмэл нь Дз аминдэм (холекальциферол)-ийг 3200 олон улсын нэгж (ОУН) тун (80 мкг)-гаар агуулсан, ногоон өнгийн желатин бүрхүүлтэй капсул юм. “Дз аминдэм–3200 ОУН” бэлдмэлийг нэг хавтгайд 10 капсулаар, нэг хайрцагт 30 ширхэгээр савласан.

“Дз аминдэм–3200 ОУН” бэлдмэлийг насанд хүрэгчид, жирэмсэн эмэгтэйчүүд хэрэглэж болно. Харин нялх, балчир хүүхдийн Дз аминдэмийн хэрэглээний хоногийн дээд тун нь 2000 ОУН буюу 50 мкг байдаг тул энэхүү бэлдмэлийг хүүхдэд өгөхийг хориглоно. Уг бэлдмэлийг гэрлээс далд, 30°C доош хэмд 24 сар хадгална.

Гурав. Бэлдмэлийг хэрэглэх заавар

“Дз аминдэм–3200 ОУН” бэлдмэлийг амьжиргааны түвшин доогуур, ядуу өрхийн жирэмсэн эмэгтэйчүүдэд **“5 хоног тутамд 1”** удаа хэрэглэж болно. Жирэмсэн эмэгтэйд зориулсан “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл”-ийг “Дз аминдэм–3200 ОУН”-тэй хавсран хэрэглэж болно. Харин “Витрум пренатал”, “Элевит” зэрэг жирэмсэн эмэгтэйд зориулсан аминдэм, эрдсийн холимог бэлдмэл нь Дз аминдэмийг 400-500 ОУН тунгаар агуулдаг тул уг бэлдмэлтэй хавсран хэрэглэх шаардлагагүй..

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 24 өдрийн
А/392 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**Бага насны хүүхдэд А аминдэм
түгээх хуваарь**

№	Хаана	6-23 сартай хүүхдийн тоо	ЭМГ-т байгаа үлдэгдэл А аминдэм, ширхэгээр		Нэмж хуваарилах А аминдэм, ширхэгээр 200 000 ОУН
			100 000 ОУН	200 000 ОУН	
1	Архангай	4424	1062	9468	-
2	Баян-Өлгий	3936	0	218	3118
3	Баянхонгор	3441	0	3535	-
4	Булган	2643	333	2080	-
5	Говь-Алтай	2038	168	564	1004
6	Говьсүмбэр	772	52	806	-
7	Дархан-Уул	4059	0	0	3240
8	Дорноговь	2858	402	582	1364
9	Дорнод	3196	106	0	2524
10	Дундговь	1601	123	1246	46
11	Завхан	3087	293	1553	676
12	Орхон	6685	0	2072	429
13	Өвөрхангай	5003	108	1243	2645
14	Өмнөговь	2660	24	0	2168
15	Сүхбаатар	2807	380	3765	-
16	Сэлэнгэ	4760	802	6968	-
17	Төв	3976	0	1032	2107
18	Увс	3327	34	2681	-
19	Ховд	3158	0	2750	-
20	Хөвсгөл	4511	0	3424	407
21	Хэнтий	2836	0	1405	911
22	Багануур дүүрэг	948	0	0	786
23	Багахангай дүүрэг	147	0	0	113
24	Баянгол дүүрэг	10094	500	8000	-
25	Баянзүрх дүүрэг	13653	200	1500	9578
26	Налайх дүүрэг	1299	0	0	1065
27	Сонгинохайрхан	14579	0	35398	-
28	Сүхбаатар дүүрэг	5180	1570	39000	-
29	Хан-Уул дүүрэг	6665	0	0	5648
30	Чингэлтэй дүүрэг	5707	2247	31968	-
Нийт		130050	8404	161258	37827.1

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 24 өдрийн
139 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**5 хүртэлх насны хүүхдэд шингэн сэлбэх уусмал болон
цайрын бэлдмэл түгээх хуваарь**

№	Аймаг/дүүргийн эрүүл мэндийн газар/төв	5 хүртэлх насны хүүхдийн тоо	Шингэн сэлбэх уусмал	Цайрын бэлдмэл
1	Архангай аймаг	12,990	25	40
2	Баянхонгор	12,421	25	30
3	Баян-Өлгий	15,371	30	40
4	Булган	7,784	20	35
5	Говь-Алтай	7,320	20	30
6	Говь-Сүмбэр	2,733	10	12
7	Дархан-Уул	13,923	30	35
8	Дорнод	11,445	23	35
9	Дундговь	5,846	15	25
10	Дорноговь	9,677	20	30
11	Завхан	9,191	35	30
12	Орхон	14,107	35	30
13	Өвөрхангай	15,693	30	35
14	Өмнөговь	9,499	30	40
15	Сүхбаатар	8,646	25	35
16	Сэлэнгэ	14,145	40	40
17	Увс	12,114	30	40
18	Хэнтий	10,320	30	35
19	Ховд	12,815	30	35
20	Хөвсгөл	18,075	40	40
21	Төв	12,819	35	35
22	Хүүхдийн төв сувилал	-	20	50
23	Эх хүүхдийн эрүүл мэндийн төв	-	50	70
Нийслэлийн эрүүл мэндийн газарт				
1	Сонгинохайрхан дүүрэг	41,885	60	70
2	Хан-Уул дүүрэг	22,479	50	70
3	Баянзүрх дүүрэг	41,255	50	70
4	Баянгол дүүрэг	28,780	50	70
5	Сүхбаатар дүүрэг	17,117	40	40
6	Багануур дүүрэг	3,350	10	10
7	Багахангай дүүрэг	500	5	10
8	Чингэлтэй дүүрэг	19,628	35	50
9	Налайх дүүрэг	4,512	10	20
Сургалтын зорилгоор:				
33	НҮБ-ын Хүүхдийн сан		20	10
34	Эрүүл мэндийн яам/НЭМҮТ		60	50
35	Нийт	416,440	1038	1297